

## АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ

/Эхний 11 сарын байдлаар/

**I. ТӨСӨВ:** Аймгийн төсвийн орлогод 9.2 тэрбум төгрөг орж, төлөвлөгөө нь 46.1 хувиар давж биелсэн байна. Өнгөрсөн оны мөн үеийнхээс 2.4 тэрбум төгрөгөөр дээгүүр гүйцэтгэлтэй байна.

Сумдын төсвийн орлогын төлөвлөгөө 6.2 хувиар давж биелсэн байна.

Орон нутгийн төсвийн зарлага 7.5 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 1.4 тэрбум төгрөгөөр буюу 30.6 хувиар дээгүүр гүйцэтгэлтэй байна.

**II. МӨНГӨ, ЗЭЭЛ:** Монгол банкны мэдээгээр ХААН, Хадгаламж, Хас банкнаас аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл 35 тэрбум төгрөгт хүрсэн нь 2010 оны жилийн эцсээс 15.4 тэрбум төгрөгөөр буюу 78.6 хувиар өсчээ.

Банкуудад хадгалуулсан иргэдийн төгрөгийн хадгаламжийн хэмжээ 15.2 тэрбум төгрөг болж, 2010 оны жилийн эцсээс 3.8 тэрбум төгрөгөөр буюу 33.3 хувиар өссөн байна.

**III. ХӨДӨӨ АЖ АХУЙ:** Ургац хураалт: Төмс 67.1 га-д, хүнсний ногоо 30.2 га-д, тэжээлийн ургамал 29.4 га-д тариалалт хийж, төмс 647.5 тн, хүнсний ногоо 212.1 тн, тэжээлийн ургамал 53.6 тн-ыг тус тус хураан аваад байна. Өнгөрсөн оны мөн үед тэжээлийн ургамал 14.4 тн, төмс 437.4 тн, хүнсний ногоо 217.2 тн тус тус хураан авсан. Энэ оны хураан авалт өнгөрсөн оноос хүнсний ногоо доогуур, төмс, тэжээлийн ургамал тус тус дээгүүр гүйцэтгэлтэй байна.

Байгалийн хадлан 11.0 мян.тн, гар тэжээл 0.7 мян.тн тус тус бэлтгэсэн нь өнгөрсөн оны мөн үеэс байгалийн хадлан, гар тэжээл тус тус доогуур гүйцэтгэлтэй байна.

**IV. АЖ ҮЙЛДВЭР:** Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл 2005 оны зэрэгцүүлэх үнээр 25.2 тэрбум төгрөг болсон нь урьд оны мөн үеийнхээс 0.6 тэрбум төгрөг буюу 2.3 хувиар доогуур байна.

Аж үйлдвэрийн салбарын борлуулалт 92 тэрбум төгрөгт хүрч, урьд оны мөн үеийнхээс 1.3 сая төгрөгөөр буюу 1.4 хувиар дээгүүр гүйцэтгэлтэй байна.

Гол нэр төрлөөс талх, хиам, нүүрс, дулаан, блок, боржуур, өнгөт тоосго, замын хавтан, эсгий үйлдвэрлэлт мөн үеэс нэмэгдсэн байна.

**V. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС:** Хэрэглээний үнийн индекс 11-р сард 2010 оны жилийн эцсийнхээс 3.1 хувиар өссөн байна. Энэ өсөлтөнд ихэнх бүлгүүдийн үнэ 1.1-19.8 хувиар өсч, эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ болон холбооны бүлгийн үнэ тогтвортой байж, хүнсний бараа, согтууруулах бус ундаа, согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис бүлгийн үнэ 3.6-4.3 хувиар буурсан байна. Өмнөх сарыхаас үнэ тарифын ерөнхий индекс 2.8 хувиар өссөн байна.

**VI. ЭРҮҮЛ МЭНД:** 1181 эх амаржиж, 1188 хүүхэд амьд төрсөн байна. 1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 23 болж урьд оны мөн үетэй адилхан, 1-5 насны хүүхдийн эндэгдэл 8 болж өнгөрсөн оны мөн үеэс 3-аар олон байна.

Халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо 579 болж, урьд оны мөн үеэс 45-аар их байгаагийн дотор заг, тэмбүү, мөөгөнцөртөх, трихоминиаз зэрэг өвчнүүд өссөн байна. Мөн энэ сард гар хөл амны өвчин 12 тохиолдол гарсан байна.

**VII. АЖИЛГҮЙЧҮҮД:** ХХҮХэлтэст бүртгэлтэй ажил идвэхитэй хайж байгаа ажилгүй иргэдийн тоо 854 болж, урьд оны мөн үеийнхээс 355 хүнээр буурсан байна. Ажилгүйчүүдийн 79.8 хувь нь 16-34 насны залуучууд, 19.3 хувь нь дээд, 2.6 хувь нь тусгай дунд, 38.6 хувь нь бүрэн дунд, 7.3 хувь нь мэргэжлийн анхан шатны боловсролтой хүмүүс байна.

3226 хүн шинээр бүртгүүлж, 2890 хүн ажилд орсны дотор 1097 нь шинэ ажлын байр байна.

**VIII. ГЭМТ ХЭРЭГ:** 219 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 51-ээр их байна.

Гэмт хэргийн улмаас 67 хүн гэмтэж, 44 хүн нас барсан байна. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд 74.7 сая төгрөгийн хохирол учирсны 70.2 саяыг нь нөхөн төлүүлсэн байна.

Гэмт хэрэгт 200 хүн холбогдон сэжиглэгдсэний 28.5 хувь нь согтуугаар, 11 хувь нь бүлэглэнгээр хэрэг үйлдсэн байна.

Нийт 2605 хүн эрүүлжигдсэн нь урьд оны мөн үеийнхээс 110 хүнээр өссөн байна. Нийт эрүүлжигдсэн хүмүүсээс 144 хүн баривчлагдаж захиргааны арга хэмжээ авахуулсан байна.



**АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС**